



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/87/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-260521 Цахим хаяг:enkhdalaid@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Эрдэнэчимэг Утас: 51-261628 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК Захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг:dabq.audit@yahoo.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
МОНГОЛ-ЯПОНЫ ЭМНЭЛГИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.АДИЛСАЙХАН
ТАНАА

2023.02.20 № 07/325
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор Монгол-Японы эмнэлгийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяанд шилжүүлсэн байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ" гэсний дагуу АШУҮИС-ийн Удирдах зөвлөлөөс тус эмнэлгийн дүрэм, бүтэц орон тоо, төсөв, эмнэлэг үйлчилгээний зардлын төлбөрийг баталж мөрдүүлсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тайлант хугацаанд санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн суурь, бодлогын өөрчлөлт ороогүй байна.

Эрүүл мэндийн яамнаас Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний анхан шатны цахим бүртгэлийн системийг Аксис системс ХХК нэвтрүүлж байна. Тус эмнэлэг 2019 оноос үйл ажиллагаандаа Axis Hospital программыг ашиглаж эмнэлгийн тусламж үйлчилгээний анхан шатны цахим бүртгэлийг хөтөлж байна. Программыг хөгжүүлж сайжруулах үйл ажиллагаа дутмаг, шаардлага хангахгүй байгаагаас эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн тооцоог 1,035,669.4 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг нь Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн хүрээнд эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, гүйцэтгэлд суурилсан төсвийн зарцуулалтын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. АШУҮИС-ийн Удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн эмнэлгийн захирлын 2022 оны А/64 дугаар тушаалаар "Төлбөртэй тусламж үйлчилгээний журам"-ыг шинэчлэн баталж, төлбөртэй тусламж үйлчилгээний үнэ тариф болон эмч, ажилчдын ажил үүргийн дагуу хийгдэх тусламж, үйлчилгээний нормыг баталсан. Мөн тайлант оны А/94 тоот тушаалаар "АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэгт ажиллах багш-эмчийн цалин хөлсийг тооцох журам"-ыг боловсруулан баталж гэрээт багш нарт цагийн бүртгэлээр бус хийсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний тоо хэмжээ, ашгаас тооцсон цалинг олгодог системтэй болсон.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89.7 гүйцэтгэлтэй байна гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,436,393,984.37	9,025,045,007.25
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3,666,537.00	899,633,753.49
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	3,666,537.00	7,872,700.00
31110	Төгрөг	3,666,537.00	1,577,900.00
31400	Замд яваа хадгаламж	-	6,294,800.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	891,761,053.49
31210	Төгрөг	-	891,761,053.49
21211	Төрийн сангийн харилцах	-	212,797,235.49
31213	Арилжааны банк дахь харилцах	-	678,963,818.00
33	АВЛАГА	1,238,013,872.80	1,020,094,767.00
33100	Ажиллагчидтай холбоотой авлага	-	19,043,867.00
33300	Татаас, санхүүжилт авлага	1,227,955,872.80	1,000,000,000.00
33500	Бусад авлага	10,058,000.00	1,050,900.00
33510	Байгууллагаас авах авлага	10,058,000.00	1,050,900.00
34	УРЬДЧИЛГАА	157,866,805.03	23,777,960.00
34710	Урьдчилгаа тооцоо	157,866,805.03	23,777,960.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	157,866,805.03	23,777,960.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,036,846,769.54	7,081,538,526.76
35100	Түүхий эд материал	5,455,285,100.11	6,194,338,269.95
35130	Эм, боох материал	3,958,628,004.11	4,697,681,173.95
35140	Жижиг багаж	1,496,657,096.00	1,496,657,096.00
35400	Хангамжийн материал	581,561,669.43	887,200,256.81
35410	Бичиг хэргийн материал	29,528,350.00	73,277,642.59
35420	Аж ахуйн материал	75,741,452.40	104,351,850.00
35430	Сэлбэг хэрэгсэл	78,561,240.00	67,722,273.30
35440	Түлш, шатах тослох материал	4,820,000.00	5,330,000.00
35450	Барилгын засварын материал	6,986,250.00	47,060,720.00
35460	Хүнсний материал	7,246,619.20	22,618,050.09
35470	Бусад хангамжийн материал	378,677,757.83	566,839,720.83
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	194,060,461,464.86	187,643,707,915.92
392	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	194,060,461,464.86	187,643,707,915.92
39200	Биет хөрөнгө	194,032,243,642.32	187,515,181,700.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	166,036,081,200.00	166,036,081,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,075,451,014.97)	(4,842,719,034.93)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86,724,470.16	351,034,112.16
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,212,162.79)	(51,047,693.31)
39205	Машин, тоног төхөөрөмж /компьютер/	42,087,123,028.42	45,063,388,910.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13,359,962,697.78)	(20,196,029,557.49)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,607,158,821.00	1,653,068,621.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(328,218,001.72)	(498,594,856.80)
39300	Биет бус хөрөнгө	28,217,822.54	128,526,215.26
39301	Программ хангамж	74,478,000.00	190,398,000.00

39302	Хуримтлагдсан элэгдэл	(55,968,305.46)	(69,759,638.74)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,202,740.00	18,202,740.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(8,494,612.00)	(10,314,886.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	201,496,855,449.23	196,668,752,923.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	211,269,250.18	140,215,470.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	211,269,250.18	140,215,470.90
41300	Өглөг	211,269,250.18	136,615,470.90
41360	Бусад өглөг	211,269,250.18	136,615,470.90
41361	Байгууллагад өгөх өглөг	211,269,250.18	136,615,470.90
41430	Урьдчилж орсон орлого	-	3,600,000.00
41430	Бусад урьдчилж орсон орлого	-	3,600,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	201,285,586,199.05	196,528,537,452.27
51200	Хуримтлагдсан үр дүн	201,191,431,868.75	196,434,383,124.67
51210	Өмнөх үеийн үр дүн	38,025,034,387.07	201,191,431,868.75
51220	Тайлант үеийн үр дүн	163,166,397,481.68	(4,757,048,744.08)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	94,154,330.30	94,154,327.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	201,496,855,449.23	196,668,752,923.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	186,516,450,683.37	21,361,206,925.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГ	174,039,498,253.37	6,655,941,251.91
120	Нийтлэг татварын бус орлого	173,911,565,614.07	6,517,018,227.22
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	173,910,707,159.07	6,517,018,227.22
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,628,682,889.00	2,664,664,564.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	114,802,167.62	161,671,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	171,421,183,170.45	2,893,777,712.92
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	732,865,566.00	725,513,997.00
120009	Бусад орлого	858,455.00	-
120009	Бусад орлого	12,314,911.00	71,390,953.29
122	Тусламжийн орлого	127,932,639.30	138,923,024.69
122001	Хандив тусламж /дотоод/	127,932,639.30	138,923,024.69
13	ТУСЛАМЖ, САНХҮҮГИЙН ОРЛОГО	12,476,952,430.00	14,705,265,674.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,871,382,700.00	2,883,866,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,513,882,700.00	2,883,866,300.00
	Улсын төсвийн санхүүжилт	357,500,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	8,605,569,730.00	11,821,399,374.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	8,605,569,730.00	11,821,399,374.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,350,053,201.69	26,114,773,170.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,350,053,201.69	26,114,773,170.18
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	22,883,755,356.69	26,098,399,028.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	6,738,869,053.73	7,356,020,746.37
210101	Үндсэн цалин	3,819,022,663.44	4,656,438,617.53
210102	Нэмэгдэл цалин	2,502,222,172.89	2,224,930,360.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	412,538,500.00	464,928,000.00
210104	Урамшуулал	5,085,717.40	9,723,768.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	889,477,768.57	936,722,770.80
210201	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	889,477,768.57	936,722,770.80
2103	Байр ашиглалтын тогтмол зардал	749,358,922.20	726,370,795.09
210301	Гэрэл, цахилгаан	575,606,118.90	498,084,367.00
210302	Түлш, халаалт	65,984,616.30	56,541,932.09
210303	Цэвэр, бохир ус	107,768,187.00	171,744,496.00
2104	Хангамж, бараа материалын зардал	444,564,426.84	491,335,815.49
210401	Бичиг хэрэг	100,069,104.00	119,834,937.93
210402	Тээвэр, шатахуун	14,525,000.00	43,870,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	36,751,035.24	32,888,584.48

210405	Хог хаягддал зайлуулах, хортон мэрэгчийн устгал	32,111,250.00	17,062,894.00
210406	БҮТЭЗүйлс	70,741,986.90	33,994,754.20
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	190,366,050.70	227,358,229.65
210408	Бараа материал акталсны зардал	-	16,326,415.23
2105	Норматив зардал	5,311,706,032.15	6,220,809,081.22
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,934,037,610.10	5,823,077,243.12
210502	Хоол хүнс	377,668,422.05	397,731,838.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	123,503,334.00	260,724,102.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,282,440.00	23,840,220.00
210604	Урсгал засвар	119,220,894.00	236,883,882.10
2107	Томилолт, зочны зардал	-	16,033,682.80
210701	Гадаад албан томилолт	-	8,189,682.80
210702	Дотоод албан томилолт	-	7,844,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	251,507,006.74	265,520,164.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	140,892,434.00	227,627,388.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	82,400,700.00	143,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157,364.00	214,948.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	20,056,508.74	29,534,728.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,374,768,812.46	9,824,861,869.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,618,000.00	463,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,220,000.00	5,240,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	8,369,930,812.46	9,819,158,869.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	466,297,845.00	16,374,142.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	438,376,445.00	16,374,142.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж	69,518,445.00	9,408,238.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	368,858,000.00	6,965,904.00
2135	Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,921,400.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,921,400.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	163,166,397,481.68	(4,753,566,244.27)
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	3,482,499.81
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	3,482,499.81
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	163,166,397,481.68	(4,757,048,744.08)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	13,839,305,494.49	17,773,595,869.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,749,570,622.59	2,863,979,695.81
120	Нийтлэг татварын бус орлого	1,749,570,622.59	2,863,979,695.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,732,361,622.59	2,797,044,836.81
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,732,361,622.59	2,797,044,836.81
120009	Бусад орлого	17,209,000.00	66,934,859.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮГИЙН ОРЛОГО	12,089,734,871.90	14,909,616,174.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,688,515,641.90	2,883,866,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,688,515,641.90	2,883,866,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,401,219,230.00	12,025,749,874.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,401,219,230.00	12,025,749,874.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,836,789,877.49	16,877,628,653.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,836,789,877.49	16,877,628,653.32
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	13,371,808,059.69	16,862,354,511.32
2101	Үндсэн цалин, нэмэгдэл урамшил	6,723,408,536.28	7,319,115,005.71
210101	Үндсэн цалин	6,723,408,536.28	7,319,115,005.71
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	889,601,032.63	936,805,788.71
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	889,601,032.63	936,805,788.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	749,358,922.20	726,370,795.09
210301	Гэрэл цахилгаан	575,606,118.90	498,084,367.00
210302	Түлш халаалтын зардал	65,984,616.30	56,541,932.09
210303	Цэвэр, бохир усны зардал	107,768,187.00	171,744,496.00
2104	Хангамж, бараа материалын зардал	312,805,895.24	748,226,425.28
210401	Бичиг хэрэг	23,406,897.00	148,084,917.77
210402	Тээвэр шатахуун	14,000,000.00	43,440,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	36,531,035.24	33,108,584.48
210404	Ном хэвлэл	33,281,100.00	-
210405	Хог хаягддал зайлуулах, хортон мэрэгчийн устгал	32,111,250.00	219,652,734.00
210406	БҮТЭЗүйлс	173,475,613.00	303,940,189.03
2105	Норматив зардал	3,978,817,624.34	6,231,783,479.42
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,686,378,513.86	5,707,479,842.00
210502	Хоол хүнс	261,714,110.48	384,481,655.42
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,725,000.00	139,821,982.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	471,300,288.00	570,664,803.57
210601	Багаж, техник, хэрэгсэл	53,413,580.00	362,500,000.00
210602	Тавилга	72,375,050.00	35,930,000.00
210604	Урсгал засвар	345,511,658.00	172,234,803.57
2107	Томиллолт, зочны зардал	-	16,033,682.80
210701	Гадаад албан томиллолт	-	8,189,682.80

210702	Дотоод албан томилолт	-	7,844,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	240,764,761.00	308,114,530.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	138,650,734.00	291,002,837.00
210802	Аудит бат, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	82,400,700.00	143,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	157,364.00	214,948.00
210808	Банк санхүүгийн байгууллагын	-	8,623,645.74
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэл бэлтгэх	11,555,963.00	130,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,751,000.00	5,240,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,661,000.00	5,240,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	464,981,817.80	15,274,142.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	438,376,445.00	15,274,142.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж	69,518,445.00	9,408,238.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	368,858,000.00	5,865,904.00
2135	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,605,372.80	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,605,372.80	-
299990	Жижиг мөнгөн сан	3,000,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,515,617.00	895,967,216.49
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,515,617.00	895,967,216.49
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,150,920.00	3,666,537.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,666,537.00	899,633,753.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	38,002,721,268.07	38,002,721,268.07
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	94,154,330.30	22,313,119.00	116,467,449.30
Үндсэн хөрөнгийн өсөлт/бууралт/			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,154,330.30	38,025,034,387.07	38,119,188,717.37
Тайлант үеийн үр дүн		163,166,397,481.68	163,166,397,481.68
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	94,154,330.30	201,191,431,868.75	201,285,586,199.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,154,330.30	201,191,431,868.75	201,285,586,199.05
Тайлант үеийн үр дүн		(4,757,048,744.08)	(4,757,048,744.08)
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	94,154,330.30	196,434,383,124.67	196,528,537,454.97

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,811,990,625.30	16,877,628,653.32	1,934,361,971.98	89.7
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	18,811,990,625.30	16,877,628,653.32	1,934,361,971.98	89.7
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	18,675,343,251.80	16,862,354,511.32	1,934,361,971.98	90.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,675,343,251.80	16,862,354,511.32	1,934,361,971.98	90.3
2101	Үндсэн цалин, нэмэгдэл урамшил	7,700,691,063.00	7,319,115,005.71	381,576,057.29	95.0
210101	Үндсэн цалин, нэмэгдэл урамшил	7,700,691,063.00	7,319,115,005.71	381,576,057.29	95.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,000,199,483.00	936,805,788.71	63,393,694.29	93.7
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	1,000,199,483.00	936,805,788.71	63,393,694.29	93.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	856,615,696.80	726,370,795.09	130,244,901.71	84.8
210301	Гэрэл, цахилгаан	596,360,000.00	498,084,367.00	98,275,633.00	83.5
210302	Түлш халаалт	86,002,496.80	56,541,932.09	29,460,564.71	65.7
210303	Цэвэр бохир ус	174,253,200.00	171,744,496.00	2,508,704.00	98.6
2104	Хангамж, бараа материалын зардал	856,673,194.00	748,226,425.28	108,446,768.72	87.3
210401	Бичиг хэрэг	178,389,664.00	148,084,917.77	30,304,746.23	83.0
210402	Тээвэр шатахуун	48,632,400.00	43,440,000.00	5,192,400.00	89.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	48,944,400.00	33,108,584.48	15,835,815.52	67.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон	289,607,300.00	219,652,734.00	69,954,566.00	75.8
210406	БҮТЭЗүйлс	291,099,430.00	303,940,189.03	(12,840,759.03)	104.4
2105	Норматив зардал	6,472,554,365.40	6,231,783,479.42	240,770,885.98	96.3
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,870,835,721.30	5,707,479,842.00	163,355,879.30	97.2
210502	Хоол хүнс	422,147,044.10	384,481,655.42	37,665,388.68	91.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	179,571,600.00	139,821,982.00	39,749,618.00	77.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	914,415,222.00	570,664,803.57	343,750,418.43	62.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	281,337,100.00	362,500,000.00	(81,162,900.00)	128.8
210602	Тавилга	13,097,000.00	-	13,097,000.00	-
210603	Хөдөлмөр хамгаалал	269,527,500.00	35,930,000.00	233,597,500.00	13.3
210604	Урсгал засвар	350,453,622.00	172,234,803.57	178,218,818.43	49.1
2107	Томилолт, зочны зардал	41,764,218.00	16,033,682.80	25,730,535.20	38.4
210701	Гадаад албан томилолт	26,475,000.00	8,189,682.80	18,285,317.20	30.9
210702	Дотоод албан томилолт	15,289,218.00	7,844,000.00	7,445,218.00	51.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	802,640,009.60	308,114,530.74	494,525,478.86	38.4
210801	Бусад нийтлэг АҮТХураамж	649,868,609.60	291,002,837.00	358,865,772.60	44.8
210802	Аудит бат, зэрэглэл тогтоох	15,000,000.00	8,000,000.00	7,000,000.00	53.3
210803	Даатгалын үйлчилгээ	67,751,700.00	143,100.00	67,608,600.00	0.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	671,200.00	214,948.00	456,252.00	32.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	112,500.00	-	112,500.00	-
210808	Банк санхүүгийн байгууллагын	10,000,000.00	8,623,645.74	1,376,354.26	86.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэл бэлтгэх	59,236,000.00	130,000.00	59,106,000.00	0.2

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,790,000.00	5,240,000.00	24,550,000.00	17.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	-	10,000,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,790,000.00	5,240,000.00	14,550,000.00	26.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
2132	Бусад урсгал шилжүүлэг	136,647,373.50	15,274,142.00	121,373,231.50	11.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж	86,247,373.50	9,408,238.00	76,839,135.50	10.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,400,000.00	5,865,904.00	44,534,096.00	11.6
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,811,990,625.30	17,773,595,869.81	1,038,394,755.49	94.5
1200041	Үндсэн үйл АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	2,085,877,554.50	2,863,979,695.81	(778,102,141.31)	137.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	2,085,877,554.50	2,863,979,695.81	(778,102,141.31)	137.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,883,866,300.00	2,883,866,300.00	-	100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн хуваарилсан хөрөнгө	2,883,866,300.00	2,883,866,300.00	-	100.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	13,842,246,770.80	12,025,749,874.00	1,816,496,896.80	86.9
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,842,246,770.80	12,025,749,874.00	1,816,496,896.80	86.9
3	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,666,537.00	3,666,537.00	
4	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		899,633,753.49	899,633,753.49	
	Төсвийн бусад мэдээлэл				
61	Байгууллагын тоо	1	1		
62	Ажиллагсдын тоо	582	526	56	90.4
62001	Удирдах ажилтан	4	4	-	100.0
62002	Гүйцэтгэх ажилтан	340	337	3	99.1
62003	Үйлчлэх ажилтан	75	45	30	60.0
62004	Гэрээт ажилтан	163	140	23	85.9

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,035,669.5 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой алдаа илэрснийг аудитын явцад залруулж бүртгүүлсэн.

Аудитаар нийт 50,709.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1,485.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 49,224.1 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 50,709.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон 188,119.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд нийт 170 мэдээ оруулахаас хугацаа хоцроосон 11 мэдээ байна	1	7,701,594.0					1	7,701,594.0
Дүн	1	7,701,594.0	-	-	-	-	1	7,701,594.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
НИЙТ		1	1			1			